

**УЛААНБААТАР ЦЭВЭР
АГААР САНААЧЛАГА
II үе**

Байгаль орчин, аялал жуулчлалын яам/ ЕСБХБ

**Евроконсалт Мотт МакДоналд
Ногоон Хөгжлийн Хөтөч ТББ
Монголиан Барристерс & Солиситорс ХХК**

2012 оны 5-р сарын 31



Улаанбаатар Цэвэр агаарын санаачлага II үе

Гэрээний дугаар:22384/EBSF2009-09-
117/01

Цэвэр агаарын сан ба төрийн бусад байгууллага
хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагаа
Сангийн өнөөгийн бүтэц зохион байгуулалтанд
хийсэн үнэлгээ

Огноо: 2012-6-5

Байгаль орчин, аялал жуулчлалын яам/
ЕСБХБ

БОАЖЯ
Засгийн газрын II байр
Нэгдсэн үндэстний гудамж 5/2
Улаанбаатар -210646
Монгол улс

ЕСБХБ
One Exchange Талбай,
Лондон хот, EC2A 2JN,
Их Британи

Боловсруулсан, шинэчилсэн тэмдэглэл

Шинэчилсэн	Огноо	Боловсруулсан	Шалгасан	Баталсан	Тайлбар
	2012-6-5	Онно ван ден Хөвюл, Дэвээ Энхээ	Пиет де Вилдт		

Улаанбаатар Цэвэр Агаар Санаачлага II төсөл

Улаанбаатар хотын гэр хороололд уламжлалт зууханд чанар муутай нүүрс түлэх нь ялангуяа өвлийн саруудад тус хотын агаарын бохирдлын томоохон шалтгаан болдог. Улаанбаатар хотын агаарын чанар нь хотын оршин суугчдын эрүүл мэнд цаашлаад улс орны эдийн засагт сөргөөр нөлөөлж байна. Иймд уламжлалт зуухыг утаа бага ялгаруулдаг зуухаар солих, түүхий нүүрсийг боловсруулсан, нүүрсэн суурьтай, утаа бага ялгаруулдаг, хэмнэлт сайтай түлшээр солих нь тулгамдаад байгаа агаарын бохирдлын асуудлын нэлээд хэсгийг богино хугацаанд шийдвэрлэх үр дүнтэй арга хэмжээний нэг гэж үзэх болсон. Боловсруулсан түлшний найдвартай нийлүүлэлт, түлш, зуухыг хослуулах, тэдгээрийг дэмжсэн орчин, стандартуудыг гаргах нь уг арга хэмжээг үр дүнтэй явуулахад зайлшгүй шаардлагатай. Засгийн газар орлуулах түлшний үйл ажиллагааны тодорхой хэсэгт дэмжлэг үзүүлэхийг Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ)-наас хүссэн юм. ЕСБХБ нь Засгийн газартай 2008 оны 9-р сараас түүхий нүүрсийг боловсруулсан түлшээр орлуулах төлөвлөгөөг боловсруулахаар хамтран ажиллаж эхэлсэн. Уг төлөвлөгөөний гол хэсгүүдийг 2009 оны 6-р сард Засгийн газраар батлуулахаар өргөн барьсан Түлш орлуулах үйл ажиллагааны ерөнхий хүрээнд тусгасан. Засгийн газар Үйл ажиллагааны хүрээний гол бүрэлдэхүүн хэсгүүдийг зарчмын хувьд баталж, 2010 оны 6-р сард Монгол Улсын их хурал Агаарын багц хуулиудыг батлаж гаргасаны дараа тус банк төслийн II үеийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр болж Үйл ажиллагааны ерөнхий хүрээний гол хэсгүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх Зөвлөхүүдийг шалгаруулж авах ажлыг гүйцэтгэсэн. Зөвлөхүүд нь Үйл ажиллагааны ерөнхий хүрээ холбогдох хэсгүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газарт хууль эрх зүй, эдийн засаг, техникийн болон чадавхийг бэхжүүлэх шаардлагатай бүхий л тусламж дэмжлэг үзүүлэх зорилготой.

Энэхүү баримт бичгийг дээр нэр заасан төслийн зорилгын хүрээнд, зөвхөн эрх бүхий талуудад зориулан гаргасан болно. Өөр зорилгоор ашиглаж үл болно.

Энэхүү баримт бичгийг ашиглах эрх бүхий талуудаас бусад этгээдүүд өөр зорилгоор ашигласнаас үүдэн гарсан үр дагавар, бусад талуудаас нийлүүлсэн мэдээллийн алдаа мадаг, орхигдсон зүйлсийн талаар манай тал ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.

Энэхүү баримт бичиг нь нууц мэдээлэл агуулсан оюуны өмчийн бүтээл болно. Бидний болон энэ баримтыг бэлтгэсэн талын зөвшөөрөлгүйгээр бусад талуудад үзүүлэхийг хориглоно.

Гарчиг

хуудас

Гарчиг	i	
Удиртгал	1	
1	Хууль эрх зүй, бодлогын орчин	2
1.1	Цэвэр агаарын сангийн хууль эрх зүйн орчин _____	2
1.1.1	Агаарын асуудалтай холбоотой хууль тогтоомж _____	2
1.1.2	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль тогтоомж _____	3
1.1.3	Захиргаа/үйл ажил ажиллагаатай холбоотой бусад хууль _____	6
1.2	ЦАС-гийн бодлогын орчин _____	6
2	ЦАС-ийн бүтэц, зохион байгуулалт	8
2.1	ЦАС-гийн албан эрх үүрэг, хамрах хүрээ _____	8
2.1.1	ЦАС-гийн Удирдах зөвлөл _____	9
2.2	ЦАС-гийн үндсэн чиг үүрэг _____	10
2.2.1	Гол чиг үүрэг _____	10
2.2.2	Үйл ажиллагаа _____	10
2.3	ЦАС-гийн санхүүжилт _____	11
2.3.1	Санхүүгийн эх үүсвэр _____	11
3	ЦАС-гийн ажлын уялдаа холбоо	13
3.1	УИХ, Ерөнхий сайд _____	13
3.1.1	Ерөнхий мэдээлэл _____	13
3.1.2	ЦАС-тай албан ёсны уялдаа холбоо _____	13
3.2	Үндэсний хороо _____	13
3.2.1	Ерөнхий мэдээлэл _____	13
3.2.2	ЦАС-тай албан ёсны уялдаа холбоо _____	15
3.3	Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын Агаарын чанарын мэргэжлийн алба _____	15
3.3.1	Ерөнхий мэдээлэл _____	15
3.3.2	ЦАС-тай албан ёсны уялдаа холбоо _____	16
3.4	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар _____	16
3.4.1	Ерөнхий мэдээлэл _____	16
3.4.2	ЦАС-тай албан ёсны уялдаа холбоо _____	16
3.5	БОАЖЯ _____	16
3.5.1	Ерөнхий мэдээлэл _____	16
3.5.2	ЦАС-тай албан ёсны уялдаа холбоо _____	17
3.6	Сангийн яам _____	17
3.6.1	Ерөнхий мэдээлэл _____	17
3.6.2	ЦАС-тай албан ёсны уялдаа холбоо _____	18
3.7	Эрдэс баялаг, эрчим хүчний яам _____	18
3.7.1	Ерөнхий мэдээлэл _____	18

Doc title

3.7.2	ЦАС-тай албан ёсны уялдаа холбоо _____	19
3.8	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам _____	19
3.8.1	Ерөнхий мэдээлэл _____	19
3.8.2	ЦАС-тай албан ёсны уялдаа холбоо _____	19
3.9	УБ хотын захиргаа _____	20
3.9.1	Ерөнхий мэдээлэл _____	20
3.9.2	ЦАС ба УБ хотын агаарын чанарын алба хоорондын албан ёсны уялдаа холбоо _____	20
3.9.3	ЦАС ба УБ хотын Байгаль хамгаалах газар хоорондын албан ёсны уялдаа холбоо _____	21
4	Дүгнэлт, зөвлөмж	22
4.1	Дүгнэлт _____	22
4.2	Зөвлөмж _____	22

Товчилсон үгс

БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ЕСБХБ	Европын сэргээн босголт, хөгжлийн банк
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МСС	Мянганы сорилтын сан
ЦАС	Цэвэр агаарын сан
ЭБЭХЯ	Эрдэс баялаг, эрчим хүчний яам

Оршил

Цэвэр агаарын сан (ЦАС) нь Улаанбаатар болон бусад томоохон хот суурин газруудад тулгараад байгаа агаарын бохирдлыг бууруулах зорилготой байгуулагдсан. Энэхүү зорилтыг хангахын тулд хууль эрх зүй, зохицуулалтын таатай орчинг бүрдүүлэх шаардлагатай байна. ЦАС болон бусад холбогдох байгууллагууд хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааны өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээний үр дүнг энэхүү тайлангаар танилцуулж байна. Төрийн тусгай сангийн үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, төрийн бусад байгууллагуудтай уялдах байдал, санхүүгийн зохицуулалт нь Төрийн тусгай сангийн тухай хуулиар зохицуулагддаг. Бусад асуудлууд нь Агаарын тухай хууль болон ЦАС-гийн дотоод дүрмээр зохицуулагдаж байна. Бусад сангуудаас ялгагдах нэг онцлог нь ЦАС нь салбар ба яамд хоорондын байгууллага бөгөөд уг санг бие даасан Зөвлөл удирддаг (бусад сангуудын хувьд БОАЖЯ зэрэг холбогдох байгууллагын ажилтан удирддаг).

Энэ тайлангаар ЦАС-гийн бүтэц, үйл ажиллагааны тогтолцоог илүү үр дүнд чиглэсэн, өгөөжтэй байхуйцаар сайжруулах зөвлөмж гаргахыг зорилгоо. ЦАС-гийн удирдах зөвлөл (УЗ) санхүүжүүлэх төслүүдийг сонгон шалгаруулах тодорхой удирдамж, журамтай байх шаардлагатайг бид хамгийн гол зөвлөмж болгон оруулж байна. Түүнчлэн Улаанбаатар болон бусад хотуудын агаарын бохирдлыг бууруулахад тодорхой хугацаа/жилүүдээр төлөвлөсөн үйл ажиллагаа явуулах шаардлагатай ЦАС-гийн үйл ажиллагааны төлөвлөлтийг хэд хэдэн жилээр боловсруулж гаргах хэрэгтэй. Ийм төлөвлөлтийн механизм байгаа ч ЦАС-гаас санхүүжүүлэх ажлын төсвийг тусгаагүй байна. Мөн ЦАС-гийн УЗ-д иргэний нийгмийн төлөөллийг оруулах, ЦАС-гийн Мониторинг үнэлгээний тогтолцоог боловсруулах шаардлагатай.

Энд хийсэн дүн шинжилгээгээр “Түлш солих үйл ажиллагааны ерөнхий бүдүүвч” баримт бичигт заасанчлан ЦАС-гийн чиг үүргийг шилжүүлэхийг бид зөвлөхгүй харин тус сангийн холбогдох дүрэм, журмуудыг боловсронгуй болгох, нэмэлт өөрчлөлт хийх замаар байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулж бэхжүүлэхэд манай зөвлөмж чиглэж байна.

Удиртгал

Монгол орны хот суурин газрууд ялангуяа Улаанбаатар хотын оршин суугчдын хувьд агаарын бохирдол нь хүрээлэн буй орчны хамгийн ноцтой асуудлын нэг болоод байна. Өвлийн улиралд агаар дахь хүхэрлэг хий /SO₂/, азотын давхар исэл /NO₂/-ийн агууламж нэлээд өндөр ялангуяа нарийн ширхэгт тоосонцорын хэмжээ олон улсын стандартаас 10 дахин, хөгжиж буй орнуудад зөвшөөрөгдсөн хэмжээнээс 3 дахин өндөр байна (Дэлхийн банк, 2009). Нарийн ширхэгт тоосонцорын нэлээд хэсэг нь гэр хорооллын зуухнаас гарч байна. Иймээс агаарын бохирдлыг бууруулах асуудлын стратегид эдгээр зуух болон ашиглаж байгаа түлшний асуудалд анхаарлаа хандуулах нь зүйтэй байна.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсын Засгийн газар агаарын бохирдлыг бууруулахад олон улсын байгууллагуудын дэмжлэг туслалцааг авч хамтран ажиллаж эхлээд байна. Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ) агаарын бохирдлыг бууруулах зорилгоор боловсруулсан түлш ашиглах болон Цэвэр агаарын сан (ЦАС)-г байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Тус Сан нь албан ёсоор 2010-2011 онд байгуулагдсан.

ЦАС-г байгуулахад дэмжлэг үзүүлэхээр Евроконсалт Мотт Мак Доналд, Ногоон хөтөч ТББ, МВС хуулийн зөвлөх компаниудын баг сонгогдон ажиллаж байгаа бөгөөд тус Сан болон бусад холбогдох байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах талд анхаарлаа хандуулж байна. Үүний тулд бид холбогдох хууль, дүрэм журам, зохицуулалтын орчин хэрхэн бүрдсэнийг судлан, холбогдох талуудтай уулзаж санал бодлоо хуваалцан, Сангийн цаашдын өдөр тутмын үйл ажиллагаа болон хамтын ажиллагаа, харилцаа холбоонд буй хийдлийг тодорхойлох зорилготой ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд бид БОАЖЯ, ЦАС, Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо, УИХ, Агаарын чанарын мэргэжлийн алба зэрэг бусад байгууллагуудтай уулзаж ярилцлаа. Эдгээр ажлын үр дүнд ЦАС ба бусад байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах замаар ерөнхий бүтэц зохион байгуулалтыг сайжруулж бэхжүүлэхэд чиглэсэн зөвлөмжүүдийг боловсрууллаа.

1 Хууль эрх зүй, бодлогын орчин

ЦАС ба бусад холбогдох байгууллага хоорондын уялдаа холбоог хангах бүтэц зохион байгуулалтын талаар агаарын бохирдол болон ЦАС-гийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, дүрэм журамд тодорхойлж зааж өгсөн байна. Тайлангийн энэ хэсэгт ЦАС ба бусад холбогдох байгууллагуудын хоорондын харилцаа, уялдаа холбоог тодорхойлсон хууль эрх зүй, бодлогын орчны талаар товч танилцуулж байна.

1.1 Цэвэр агаарын сангийн хууль эрх зүйн орчин

ЦАС-тай холбоотой хууль эрх зүйн орчинд дэлгэрэнгүй судалгаа, дүн шинжилгээ хийж, тусад нь тайлан гаргасан билээ¹. Тиймээс энэ тайланд ЦАС ба бусад байгууллага хоорондын уялдаа, холбоог хангах бүтэц зохион байгуулалтын асуудлыг голлон авч үзлээ.

Агаарын болон Төрийн тусгай сангийн тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах замаар ЦАС-г 2010 онд албан ёсоор байгуулсан.

1.1.1 Агаарын асуудалтай холбоотой хууль тогтоомж

Агаарын тухай хууль (2012)-ийн 25 дугаар зүйлд Цэвэр агаарын санг байгуулах тухай заалтыг оруулж өгсөн байна.

Ерөнхий бүтэц:

Бүтэц зохион байгуулалтын асуудалд дараахи гол асуудлуудыг тусгаж өгсөн байна. Үүнд:

1. ЦАС нь **Тусгай сангийн тухай хуулийн** дагуу ажиллана.
2. Санг **Байгаль орчин, аялал жуулчлалын яам** (БОАЖЯ)-ны дэргэд байгуулна.
3. Уг Санг холбогдох талуудын төлөөллөөс бүрдсэн **Сангийн Удирдах зөвлөл** удирдана.
 - Удирдах зөвлөлийн гишүүдийг **Ерөнхий сайд** томилно.
 - Удирдах зөвлөлийн дүрмийг Монгол Улсын Засгийн газар батлана.

Хуулинд холбогдох талуудын үүрэг хариуцлагыг дараахи байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- **Улсын их хурал** нь Агаарын тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж, төсөв батлан түүний зарцуулалтанд хяналт тавина.
- **Ерөнхийлөгч** нь хэрэгжилт ба зохицуулалтын ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй. Ерөнхийлөгч нь үйл ажиллагаанд нь хяналт тавих, зохицуулах болон Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Үндэсний хороог байгуулна. Тус **Үндэсний хороо** нь олон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор цахим хуудас ажиллуулдаг Гүйцэтгэх албатай байх бөгөөд уг албаны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ¹.

¹ Цэвэр агаарын сан (ЦАС)-гийн хууль эрх зүйн орчинд хийсэн судалгаа, дүн шинжилгээ, 2012-3 сар

- **Засгийн газар** нь (1) УИХ-аар агаарын бохирдлыг бууруулах ажиллагаанд зарцуулах санхүүгийн нөөцийг хянан үзэж батлуулах; (2) агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөр боловсруулах; (3) цахилгааны хэрэглээний сүлжээг өргөтгөх, сайжруулах; (4) тогтоосон бүсүүдэд цахилгааны үнийн 50%-ийн татаас олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх; (5) цахилгаан ба цахилгаан халаагуурын хангалтыг сайжруулах; (6) хий, цахилгаан, боловсруулсан нүүрсээр халаах хувилбаруудыг дэмжих, зуухнуудыг нэгдсэн халаалтын системд холбох; (7) агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжих; (8) гол дэд бүтэц (хотын тэлэлтийг бууруулах үүднээс авто ба төмөр зам, гүүр зэрэг) байгуулах төлөвлөгөөг боловсруулах; (9) агаарын бохирдлыг бууруулах хангалттай санхүүжилт бий болгох үүднээс бонд/үнэт цаас гаргах; (10) татаасын хөтөлбөр хэрэгжүүлэх ажиллагааны дүрэм журам боловсруулах; (11) гэр, орон сууц, бусад барилга байгууламжуудыг барих стандартуудыг боловсруулах; (12) агаарын чанарын асуудлаар байнга/ өдөр бүр мэдээлэл сурталчилгаа явуулах үүрэгтэй.
- **Улаанбаатар хотын зөвлөл** нь тусгай бүсүүдэд агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааны төсвийг баталж, Хотын Захирагчид агаарын бохирдлын асуудлуудтай холбоотой асуудлыг танилцуулж, гэр хорооллын оршин суугчдын орлогын түвшинг нэмэгдүүлэх, гэрийн дулааллагыг сайжруулах, сайжруулсан зуух болон боловсруулсан түлш хэрэглэхийг дэмжих үүрэгтэй.
- Тус хуулинд **иргэд, аж ахуйн нэгжүүдэд** түүхий нүүрс болон агаарын бохирдлыг нэмэгдүүлэх бусад материалыг түлшинд хэрэглэхийг хориглож харин шингэрүүлсэн нефтийн хий зэрэг агаарын бохирдлыг бууруулахад чухал үүрэгтэй технологийг нэвтрүүлэхэд туслах, хамтран ажиллах үүрэгтэй.

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль нь ЦАС-гийн орлогын эх үүсвэрүүдийг зааж өгсөн байна. Хууль нь ЦАС гэж дурьдаагүй байна. Уг хуулинд агаарын бохирдлын төлбөрийг “холбогдох төрийн удирдлагууд”-д төлж олборлосон нүүрс бүх нүүрс (экспортод гаргасан нүүрсийг оруулан)-ний нэг тонн бүрт 1-2 төгрөгний агаарын бохирдлын төлбөрийг тогтоосон байна. Харин боловсруулсан ба (хагас) коксжсон нүүрсийг энэ татвараас чөлөөлсөн байна. Агаарын бохирдлын төлбөрийг төлөгч нь авто машин эзэмшигчид ба үйлдвэрийн газрууд байна.

1.1.2 Төрийн тусгай сангуудтай холбоотой хууль тогтоомж

Төрийн тусгай сангийн тухай хууль (2010-6 сар)-нд өнөөгийн ажиллаж байгаа 28 төрийн тусгай сангуудын үйл ажиллагааны цар хүрээг тогтоож өгсөн бөгөөд эдгээрийн нэг нь Цэвэр агаарын сан юм. Уг хуулиар эдгээр сангуудын дараахи үйл ажиллагаа/элементүүдийг зохицуулдаг. Үүнд:

1. Сангуудын орлогын эх үүсвэр
2. Сангуудын хөрөнгийн ашиглалт, зарцуулалт
3. Санхүүгийн зохицуулалт
4. Хяналт мониторинг ба тайлагнах үйл явц
5. Хориглосон үйл ажиллагаанууд болон торгууль шийтгэл

Орлогын эх үүсвэрүүд:

Doc title

Тусгай сангийн тухай хуулиар ЦАС-гийн санхүүжилтийн ихэнхи хувийг улсын төсвөөс бүрдүүлэх бөгөөд дараахи эх үүсвэрүүдээс нэмэлт санхүүжилтийг бүрдүүлж болно гэжээ. Үүнд:

1. Олон улсын байгууллагууд, хандивлагч орнууд, гадаад ба дотоодын байгууллагууд, иргэдийн хандив тусламж
2. Төр засгийн газраар дамжуулан гадаад орнууд, олон улсын байгууллагуудын зээл тус тус орж болно

ЦАС-гийн төсвийн үндсэн орлогыг дараахи эх үүсвэрээс бүрдүүлнэ. Үүнд:

1. Агаарын бохирдлын төлбөр, нөхөн төлбөрүүд
2. Бусад орлого

ЦАС-гийн ашиглалт, зарцуулалт:

Хуулинд ЦАС-гийн ашиглалт зарцуулалтыг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

1. Агаарын чанарыг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах зорилго бүхий шинэлэг арга, технологиудыг нэвтрүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
2. Үр дүн нь баталгаажсан боловсруулсан түлш, зуухнуудыг үйлдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх ба тэдгээрийг худалдаж авахад татаас олгох;
3. Агаарын чанарыг хамгаалахтай холбогдон агаарын чанарын нөхцөл, тэдгээрийн өөрчлөлтөнд хяналт мониторинг, дүн шинжилгээ, үнэлгээ хийх, стандарт, гарын авлага, дүрэм журам, аргачлал боловсруулах чиглэлээр чадавхи бий болгох, үнэлгээ дүн шинжилгээнд чиглэсэн төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх;
4. Эрчим хүчний хэмнэлт болон байшин барилгын дулаалгыг сайжруулахад чиглэсэн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
5. Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн олон нийтийн санал санаачлага, төсөл хөтөлбөрүүдийг дэмжих;
6. Сэргээгдэх эрчим хүч ба цэвэр технологийг хөгжүүлэх нэвтрүүлэхэд чиглэсэн төсөл, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
7. Агаарын бохирдлыг бууруулах талаар олон нийтийн сургалт сурталчилгааны мэдээлэл бий болгох гэж заасан байна.

Санхүүгийн зохицуулалт:

Тусгай сангийн тухай хуулинд төрийн тусгай сангуудын санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын талаар дараахи заалтуудыг зааж өгсөн байна. Үүнд:

- Санхүүжилтийн хуваарилалтыг шийддэг зөвлөлтэй байна.
- Санхүүжилтийг Төрийн сангийн дотор Сан бүрийн **тусгай дансанд** байршуулах бөгөөд хүүг тухайн Сангийн дансанд төлнө.
- Олон улсын гэрээ хэлэлцээрт заагаагүй бол **тусгай санг Төрийн бус сан (арилжааны банкны дансанд)-гуудад байршуулахыг хориглоно.**
- Хуулинд зааснаар тус Сангийн үйл ажиллагаанд (1) Байгаль орчны сайд; (2) УИХ-ын Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хороо; (3) Улсын нөөцийн сан гурван тал **хяналт тавих** буюу үндэсний аудитын газраас аудит хийлгэх хүсэлт тавих эрхтэй байна.

- Төрийн сангаас тусгай сангуудад дараахи **хоёр төрлийн төлбөрийг** хийдэг. Үүнд:
 - Урьдчилгаа олгож гүйцэтгэлээр санхүүжүүлэх буюу тухайн ажил, үйлчилгээний онцлог, шаардагдах хөрөнгийн хэмжээтэй уялдуулан үе шаттайгаар санхүүжүүлэх
 - шууд санхүүжүүлэх буюу ажил, үйлчилгээг гүйцэтгэсний дараа санхүүжилтийг бүрэн хэмжээгээр нэг удаа олгох

Дээрх хувилбарын алийг нь ашиглахыг Сангийн яам шийднэ. ЦАС-гийн Гүйцэтгэх захирлын хэлснээр уг Сан нь эхний хувилбарыг ашигладаг. Төрийн тусгай сангийн тухай хуулинд Сангийн яам уг Сангийн хөрөнгийн эх үүсвэрийг Сангийн дансанд шилжүүлэх шийдвэр гаргаж, тэндээс холбогдох төсөл ба хэрэгжүүлэгч байгууллагын дансанд шилжүүлнэ гэж заасан байна. Төсвийн ерөнхийлөн захирагч (БОАЖ-ын сайд) нь дараагийн санхүүжилтээ авах хүсэлт гаргахын өмнө өмнөх зарцуулалтын тайланг хянаж батлана. Төрийн сангаас шилжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох төсөл болон хэрэгжүүлэгч байгууллагад шууд шилжүүлэхийг хориглоно. Энэ жилээс Сангийн яам ЦАС-нд хийгдэх санхүүжилтийг гүйцэтгэлийг нь хянаж олгодог болсон. Хэрэв үйл ажиллагаа он дамжвал ЦАС нь тухайн үйл ажиллагааны үлдэгдэл санхүүжилтийг дараа жилийн төсөвтөө дахин тусгаж болно. ЦАС-гийн хөрөнгийн эх үүсвэр улсын төсвөөс бүрддэг. Сангийн яам оны эхэнд агаарын бохирдлын төлбөрөөс орох орлогыг ерөнхийд нь урьдчилан тооцоолж, уг тооцоонд тулгуурлан ЦАС-гийн тухайн жилийн төсвийн дээд хэмжээг тогтоодог.

Хяналт мониторинг ба тайлагнахад тавигдах шаардлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь **зарцуулалтын тайланг** хагас, бүтэн жилээр гаргаж Сангийн яаманд хүргүүлэх үүрэгтэй. ЦАС-гийн санхүүжилтээр үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа гэрээт аж ахуйн нэгж буюу хэрэгжүүлэгч байгууллагууд нь ЦАС-гийн Гүйцэтгэх захиралд санхүүгийн тайлангаа гаргаж өгнө. Уг тайлангуудад **Төрийн аудитын тухай хуулийн хүрээнд аудит хийлгэнэ**. Жилийн санхүүгийн тайлан болон аудиторын дүгнэлтийг уг тайланг гаргасанаас хойш 20 хоногийн дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлнэ.

Тусгай сангуудын **санхүүгийн хяналтыг Төрийн санхүүжилт ба удирдлагын тухай хуулинд** заасны дагуу явуулна. Сан бүрийн зарцуулалтын тайланд УИХ-ын холбогдох байнгын хороод хяналт тавих эрхтэй. Сангийн яам нь бүх Сангуудын зарцуулалтанд хяналт тавих үүрэгтэй. ЦАС-гийн Гүйцэтгэх захирал нь тус Сангаас санхүүжүүлсэн бүх төсөл, үйл ажиллагааны зарцуулалтанд хяналт тавих үүрэгтэй.

Хориглосон заалт ба шийтгэл:

Хуулиар дараахи хоёр үйл ажиллагааг хориглосон байна. Үүнд:

- Сангийн зорилгод нийцээгүй үйл ажиллагаа болон төсвөөс хэтэрсэн үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй байх.
- Төрийн сангийн бус дансанд хөрөнгийн эх үүсвэрийг байрлуулахгүй байх гэж тус тус заасан байна.

Дээрх хоёр заалтыг зөрчсөн, Сангийн хөрөнгийг эрх бүхий хүний зөвшөөрөлгүйгээр ашигласан буюу зарцуулсан, зөвшөөрөгдөөгүй талд Сангийн хөрөнгө санхүүжилтийг олгосон хүнд 40,000-60,000 төгрөгийн торгуулийг шүүгч ба улсын байцаагчийн шийдвэрээр олгож болно гэж заасан бөгөөд үүнийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудал болгон авч

үзээгүй байна. Санхүүгийн тайланг хугацаа хоцроох болон буруу гаргах тохиолдолд улсын байцаагч байгууллагад 200,000 төгрөг, албан тушаалтанд 50,000 төгрөгийн торгууль оногдуулна.

1.1.3 Захиргаа/үйл ажиллагаатай холбоотой бусад хууль

ЦАС-гийн бараа үйлчилгээ худалдан авах бүх үйл явц **Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн** дагуу явагдах ёстой учраас уг хууль нь тус Сангийн хувьд чухал ач холбогдолтой.

Төрийн байгууллагын төсвийн төлөвлөлт нь Төрийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулиар зохицуулагддаг.

1.2 ЦАС-гийн талаарх бодлогын орчин

Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичиг бол **Үндэсний хөгжлийн стратеги (2007-2021)** бөгөөд уг баримт бичигт агаарын бохирдлыг гол тулгараад байгаа асуудлуудын нэг гэж үзсэн ч байгаль орчны бохирдлыг бууруулах, арилгах асуудлыг стратегийн 2 дахь зорилтонд тавьсан байна. Энэ зорилтыг хангахад шинэ төрлийн түлшний эх үүсвэрүүдийг бий болгох зорилт тавьсан.

Монгол улсын Үндэсний хөгжлийн стратеги (2007-2021)-ийн баримт бичигт стратегийн зорилт 2, 3-т дараахи зүйлийг тусгасан байна. Үүнд:

2. Байгаль орчны бохирдол, доройтлыг хязгаарлан зогсоох чиглэлээр

Хэрэгжүүлэх стратеги:

- Шинэ технологи нэвтрүүлэн нүүрснээс шингэн ба хийн түлш гаргаж авах (шингэрүүлсэн хийн түлш)
- Сэргээгдэх эрчим хүч ашиглах хувь хэмжээг нэмэгдүүлж, нар, салхи, усны эрчим хүчний эх үүсвэрийн дан болон хоршсон хэрэглээг хөгжүүлэх;

3. Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, хүн амын бага ба дунд орлоготой болон ядуу хэсэгт чиглэсэн санхүүгийн бодлого хэрэгжүүлэх

- Мянганы хөгжлийн зорилтуудын хүрээнд байгаль орчны тогтвортой байдлыг хангах, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтүүдэд дасан зохицоход чиглэсэн үйл ажиллагааны төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх. Агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах, ургамал амьтны нөөцийг хамгаалахад чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлэх гэж заасан байна.

УИХ-аас “**Шинэ бүтээн байгуулалт**” дунд хугацааны үндэсний хөтөлбөрийг 2010-6-25-нд батлан гаргажээ. Тус хөтөлбөрийг 2010-2012 ба 2013-2016 он гэсэн хоёр үе шаттайгаар 2010-2016 онуудад хэрэгжүүлэхээр батлан гаргасан. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт нь 18.2 их наяд төгрөг бөгөөд уг хөтөлбөрт “утаагүй УБ” дэд хөтөлбөрийг 1.2 их наяд төгрөгийн төсөвтэйгээр оруулсан байна. Уг дунд хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтэнд **Эдийн засгийн байнгын хороо** хяналт тавих юм.

Үндэсний нүүрсний талаар баримтлах бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах ажил сүүлийн 6 жилийн хугацаанд хийгдэж байна. Энд тэргүүн ээлжинд ашиглах уурхайнуудыг тодорхойлж, нэмүү өртөг шингэсэн ямар төрлийн нүүрс үйлдвэрлэх,

Doc title

үйлдвэрлэлийг хэрхэн дэмжих зэрэг асуудлыг тусгах хэрэгтэй байна. Төслийг УИХ-д өргөн барьсан байна.

2 ЦАС-ийн бүтэц, зохион байгуулалт

2.1 ЦАС-гийн албан ёсны эрх үүрэг, хамрах хүрээ

Цэвэр агаар сан ба түүний бүтэц зохион байгуулалтыг 2010-2011 онуудад боловсруулж гаргасан. Тус Сан Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 10 сард 273 тоот тогтоолоор байгуулагдаж, засгийн газар ЦАС-гийн Удирдах зөвлөлийн ажиллах журам, уг Санг ажиллуулахад шаардлагатай санхүүжилтийг баталсан. ЦАС-гийн Удирдах зөвлөлийн саналыг үндэслэн БОАЖЯ ЦАС-гийн дүрэм, бүтэц зохион байгуулалт, стратегийг баталсан тушаалыг 2011 онд гаргаж 2011-5 сараас ЦАС албан ёсоор ажиллаж эхэлсэн байна.

ЦАС-гийн стратегид дараахи зорилго зорилтуудыг тусгажээ. Үүнд:

Зорилго: “Тусгай сангийн тухай хуулийн 5.1-д заасанчлан агаарыг хамгаалах, агаар бохирдохоос урьдчилан сэргийлэх, агаар бохирдуулагч бодисын хаягдлыг бууруулж хяналт тавихтай холбоотой Сангийн үйл ажиллагааг хөгжүүлэх, санхүүжилтийг эдгээр үйл ажиллагаанд зориулсан улсын нэгдсэн төсөв, хандив, тусламжаас бүрдүүлэх”;


Зорилт: “агаар хамгаалах, агаар бохирдохоос урьдчилан сэргийлэх, агаар бохирдуулагч бодисын хаягдлыг бууруулах зэрэг үйл ажиллагаанд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх; эдгээр үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг бий болгох, Сангийн дэмжлэг, санхүүжилтийг үндэслэлтэй, үр дүнтэй зарцуулах”.

ЦАС нь дараахи бүтэц, зохион байгуулалттайгаар ажиллаж байна. Үүнд:



2.1.1 ЦАС-гийн Удирдах зөвлөл CAF Board

ЦАС-гийн Удирдах зөвлөл нь дараахи бүрэлдэхүүнтэй:



Ерөнхий сайд нь ЦАС-гийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлана. Удирдах зөвлөлийн гол чиг үүрэг:

- ЦАС-гийн үйл ажиллагааг зохион байгуулах, талуудын оролцоог хангах үүрэгтэй.
- Удирдах зөвлөлийн үйл ажиллагаа:
 - 1 Үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн зарцуулалтын тайланг хэлэлцэж батлах
 - 2 Сангийн дүрэм баталж, нэмэлт өөрчлөлт оруулах
 - 3 Гүйцэтгэх захирлыг томилох ба чөлөөлөх
 - 4 ЦАС-гийн төсөл, хөтөлбөрийн төсвийг батлах
 - 5 Үйл ажиллагаа, тэдгээрийн зарцуулалтанд хяналт тавих
 - 6 ЦАС-гийн гүйцэтгэх албаны үйл ажиллагаанд хяналт мониторинг тавих
 - 7 Холбогдох төрийн байгууллагуудын гишүүд болон бусад холбогдох талуудад үйл ажиллагааны төсөв ба зарцуулалтын тайланг хүргүүлэх
 - 8 ЦАС-г холбогдох мэдээ, мэдээллээр хангах

2.2 ЦАС-гийн үндсэн чиг үүрэг

2.2.1 Гол чиг үүрэг

ЦАС-гийн үндсэн чиг үүрэг нь зарцуулалтыг төлөвлөж, хяналт тавих үүрэгтэй. Тус Сангийн стратегит дараахи чиг үүргийг оруулсан байна:

- Сангийн орлого, зарцуулалтын төлөвлөгөө нь улсын төсөвт Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын багцад орсон байна.
- Удирдах зөвлөл нь жилийн орлого, зарцуулалтын төсөв болон хагас, бүтэн жилийн тайланг хэлэлцэх бөгөөд эдгээрийг Сайд батална.
- Төрийн байгууллагын захиргаа, санхүүжилт, худалдан авалт, аудитад тавигддаг шаардлага, үйл явцыг дагаж ажиллана.
- Жилийн зарцуулалтын тайланг аудиторын хийсэн дүгнэлт /аудит хийгдэж дууссанаас хойш 20 өдөрт багтаж/-ийн хамт өдөр тутмын сонингоор дамжуулан олон нийтэд танилцуулна.

2.2.2 Үйл ажиллагаа

ЦАС-гийн хамгийн чухал чиг үүрэг бол холбогдох талуудтай хамтран Удирдах зөвлөлөөс тогтоосон үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх ажил юм. ЦАС-гаас санхүүжүүлэн хэрэгжүүлж буй төслүүдийн өдөр тутмын зохицуулалтыг БОАЖЯ, УБ хотын захиргаа зэрэг хамтрагч/захиалагч байгууллагууд хариуцан ажилладаг.

ЦАС-гийн үйл ажиллагаанд дутагдаж буй нэг чухал зүйл бол урт хугацааны төлөвлөлт байхгүй байгаа явдал юм. ЦАС нь бие даан төсөл санал болгох, эсвэл санхүүжүүлэхээс татгалзах эрхгүй учраас тус сан үйл ажиллагаагаа урт хугацаагаар төлөвлөх боломжгүй юм. Санхүүжүүлэх үйл ажиллагааг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтүүд ч байхгүй байна.

Бодлого боловсруулах

Агаарын бохирдолтой холбоотой бодлого боловсруулж, хэрэгжилтэнд хяналт тавих үүргийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам хүлээдэг. Харин боловсруулсан түлшний асуудлыг Эрдэс баялаг, эрчим хүчний яам хариуцдаг. Эдгээр яамдын холбогдох ажлын хэсэгт ЦАС-гаас төлөөлөл оруулан агаарын талаарх бодлого, стратеги боловсруулахад сангийнханы оролцоог хангах шаардлагатай юм. Үүнийг ЦАС-гийн дүрэмд тусгах хэрэгтэй.

Худалдан авалт ба санхүүжилт

Үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсаны дараа ЦАС нь төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авахтай холбоотой гарсан дүрэм журамд нийцүүлэн тендерийг албан ёсоор зарлан явуулдаг. Гэрээний тухайд Монгол Улсын Засгийн газраас гаргасан гэрээний загварыг тухайн нөхцөлд тохируулан авч ашигладаг бөгөөд Хууль зүйн яамнаас гаргасан гэрээ, дүрэм, журмын загвар болон алданги тооцох маягтуудыг ашигладаг.

ЦАС нь төлбөр тооцоогоо Төрийн сангаар дамжуулан хийдэг. Хуулинд зааснаар ЦАС нь арилжааны банкны данс ашиглах боломжгүй. Бусад сан, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах боломжийг нээлтэй байлгахын тулд арилжааны банкинд данстай байх хувилбар нь ЦАС-д чухал. Тухайлбал, ЖАЙКА олон улсын байгууллага арилжааны банкаар дамжуулан зээл олгох сонирхолтой байгаа. Энэ асуудлаар ЦАС нь ХАС, ХААН банкуудтай урьдчилсан байдлаар уулзаж ярилцаад байна.

Хяналт мониторинг

ЦАС-гийн санхүүжилтээр хэрэгжиж буй үйл ажиллагаанд тавих хяналт, үнэлгээний тогтолцоо байхгүй байна. Тус Сангийн ажилтнуудаас ч ийм тогтолцоог бий болгох нь үйл ажиллагаанд нь чухал гэдгийг илэрхийлсэн юм.

Хууль тогтоомжийн эрэгжилт

“Түлш солих үйл ажиллагааны ерөнхий бүдүүвч” баримт бичигт зааснаар холбогдох бодлогын хэрэгжилт хэрэглэгчид рүү бус харин үйлдвэрлэгчид рүү илүү чиглэсэн байна. Үйлдвэрлэгчид нь бүтээгдэхүүний баталгаажуулалт, шошго хаяганд тавьдаг шаардлагуудыг даган мөрдөх үүрэгтэй ажилладаг. Монгол Улсын хуулийн дагуу үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүнд хяналт шалгалтыг тавих үүрэгтэй байгууллага нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газар байна.

Боловсруулсан түлшний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжилтийг хянах үүргийг Хэсгийн ахлагчдад хариуцуулдаг. Гэвч хуулиар хэсгийн ахлагчид үүнийг хариуцах эрх үүрэг байдаггүй, энэ нь хөдөө орон нутагт байгаль хамгаалагчдад олгогдсон зарим үүрэгтэй төстэй байна.

Харилцаа холбоо/сурталчилгаа:

Олон нийтийн мэдээлэл, сурталчилгаа явуулах ажлыг ЦАС БОАЖЯ-тай хамтран гүйцэтгэдэг. 2011 онд энэ чиглэлээр явуулах үйл ажиллагаанд зориулж 500 сая төгрөгийг БОАЖЯ-нд шилжүүлсэн. Гэрээнд олон нийтийн мэдээлэл сурталчилгаа, зөвлөлдөх үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөөг хавсралтаар оруулж өгсөн. БОАЖЯ нь мэдээлэл сурталчилгааны хөтөлбөрийг боловсруулан МСС-тай хамтран ажилладаг. Харилцаа холбоо, хамтын ажиллагааны стратегийн хэрэгжилтийг тусад нь авч үзэж тайлан гаргаж байна.

Түлшний чанарын шинжилгээ:

Энэ талаар Эрдэс баялаг, эрчим хүчний яам (ЭБЭХЯ)-тай хамтран ажилладаг бөгөөд тус яам нь УБ хотын засаг захиргаатай түлшний асуудлаар хамтран ажиллаж байна. ЦАС нь түлшний чанарын шинжилгээний ажиллагаанд шууд оролцдоггүй.

2.3 ЦАС-гийн санхүүгийн нөөц

2.3.1 Санхүүгийн нөөц

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулинд зааснаар ЦАС-гийн орлого нь агаарын бохирдлын төлбөрөөс бүрдэнэ. Уг хуулинд зааснаар *нүүрс олборлогчид, органик уусгагч үйлдвэрлэгчид ба импортлогчид, авто машин эзэмшигчид болон агаарын бохирдол үүсгэгч эх үүсвэрүүдийн тусгай зөвшөөрөл эзэмшигчид агаарын бохирдлын төлбөр төлөх үүрэгтэй бөгөөд тухайн төлбөр нь ЦАС-нд төвлөрч байх ёстой*. ЦАС-гийн ажилтнуудын хэлж байгаагаар одоогоор зөвхөн нүүрс олборлогчдын төлбөр тус Санд орж ирж байна. Уул уурхайн компаниудаас одоогоор нэг тонн нүүрсэнд 1000 төгрөг төлж байгаа нь хуулинд заасан 1 кг-д 1-2 төгрөгийн татварын доод хязгаартай таарч байна. Тус сан 2011 онд 28 сая ам долларын орлого олох тооцоотой байсан бөгөөд цаашид нэмэгдэнэ гэж үзэж байна. 2012 онд олборлож буй ашигт малтмалын дундаас хамгийн их орлого бүрдүүлж байгаа нөөц нь нүүрс байна. 2011 онд зэс байсан байна. (ЭБЭХЯ, 2011).

Монгол дахь нүүрсний олборлолт

Жил	Хэмжээ /сая тн/
2008	9.4
2009	13.2
2010	25.3
2011	32.4 ²

² Налайхаас УБ-д оруулж байгаа нүүрс (ойролцоогоор 1.5 сая тн)- ийг оруулахгүй дүн

2012	40.0
------	------

Эх сурвалж: ЭБЭХЯ, 2012

Дээрх төлөвлөлтөөр ЦАС-гийн төсөв ирэх жилүүдэд нэлээд нэмэгдэхээр харагдаж байна.

Өөр бусад эх үүсвэрүүдээс ч тус Санд орлого орох боломжтой. Тухайлбал: 2012-6 сараас эхлэн авто машин эзэмшигчид төлбөр төлөх ёстой. Түүнчлэн нэлээд олон химийн бодисоос тэдгээрийн бохирдуулалтын чанараас хамаарсан татвар авдаг. Монгол Улсын Засгийн газрын 273 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар бохирдуулагчийн төлбөр ноогдуулах химийн бодисын жагсаалтыг баталж өгсөн. Тэдгээр 25 химийн бодисын ялгаруулалтаас нэг килограмм тутамд 10-30 төгрөгийн төлбөр авдаг байхаар тогтоож өгсөн. Уг химийн бодисуудыг үйлдвэрлэдэг болон импортолдог компаниуд бохирдлын төлбөр төлөх үүрэгтэй. Энэ төлбөр нь тухайн химийн бодисуудыг хадгалдаг аж ахуйн нэгжүүдэд хамаарахгүй байна. Ийм төрлийн химийн бодист бензин, спирт, эфир, гликол зэрэг бодисууд орж байна. Татварын ерөнхий газар уг төлбөрийг цуглуулдаг. Одоогоор уг төлбөр нь ЦАС-гийн төсөвтэй хэрхэн холбогддог нь оролцогч талуудын хувьд тодорхой бус хэвээр байна. Энэ нь агаарын бохирдлын төлбөрүүдийг тус Санд төвлөрүүлэх нэгдсэн механизм байхгүй байгааг харуулж байна. Сангийн яамны ажилтнуудын тайлбарласнаар тус яам нь оны эхэнд агаарын бохирдлын төлбөр хураамжаас орох орлогыг урьдчилан тооцож ЦАС-гийн төсвийн хэмжээг тогтоодог байна.

Сангийн төсвийн хуваарилалт

ЦАС-гийн хөрөнгийн нөөцийг Төрийн санд байршуулдаг байхаар холбогдох дүрэмд заасан байна. ЦАС-гийн ажилтнуудын тайлбарлаж байгаагаар Сангийн яам Санд орох орлогын төлөвлөлтийг оны эхэнд урьдчилан тооцож, тухайн тооцсон хэмжээгээр санхүүжилтийг шилжүүлдэг. Дүрэмд “Тус Сангийн хөрөнгийг агаарыг хамгаалах, бохирдлоос сэргийлэх, агаар бохирдуулагч бодисын хаягдлыг бууруулах зэрэг ерөнхий заалт/зорилтод чиглэсэн төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэхэд зарцуулж, зарцуулалтанд хяналт тавьж, тайлагнах” тухай заасан байна. Цэвэр агаарын сан нь (1) өөрийн үйл ажиллагааны төсөв, (2) Сангийн төсөв гэсэн хоёр төрлийн төсвөөс бүрдэнэ. Төсвийн санхүүжилт авах хүсэлтийг БОАЖЯ гаргаж, Сангийн яам хяналт тавина.

3 ЦАС ба бусад байгууллага хоорондын уялдаа холбоо

Энэ хэсэгт ЦАС-гийн харилцагч гол байгууллагууд, тэдгээртэй хэрхэн уялдаа холбоотой хамтран ажилладаг талаар товч авч үзлээ. ЦАС нь албан ёсоор дараахи байгууллагуудтай холбоо харилцаатай ажиллаж байна. Үүнд:

1. Улсын их хурал
2. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо
3. Агаарын чанарын мэргэжлийн алба
4. Байгаль орчин, аялал жуулчлалын яам
5. Сангийн яам
6. Эрдэс баялаг, эрчим хүчний яам
7. Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам
8. Улсын мэргэжлийн хяналтын ерөнхий газар
9. УБ хотын агаарын чанарын алба (Нийслэлийн агаарын чанарын алба), нийслэлийн байгаль хамгаалах газар
10. УБ хотын захиргаа/Дархан /Эрдэнэт

3.1 УИХ, Ерөнхий сайд

3.1.1 Ерөнхий мэдээлэл

Улсын их хурал /76 гишүүнтэй/ нь хууль, бодлого, төсөв /ЦАС-г оруулан/-ийг хэлэлцэн батлах эрх бүхий дээд байгууллага.

3.1.2 ЦАС-тай албан ёсны уялдаа холбоо

Ерөнхий сайд нь ЦАС-гийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилдог. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орох өөрчлөлт болон сангийн ажлын албаны бүтэц, орон тоог баталдаг.

УИХ нь ЦАС-гийн төсвийг баталж, тухайн Сангийн үйл ажиллагаа (сангийн дотоод дүрмийг ЦАС-гийн Удирдах зөвлөл батладаг) болон агаарын бохирдолтой холбоотой хууль тогтоомжийг хянаж үзэж батлах үүрэгтэй. Түрүүчийн БОАЖ-ын сайд (Удирдах зөвлөлийн тэргүүн) УИХ-ын гишүүн байсан гэдэг утгаараа ЦАС УИХ -тай шууд холбоотой байсан. УИХ нь ЦАС-гийн өнөөгийн бүтэц, зохион байгуулалтыг боломжийн гэж үзэж байгаа ч цаашид Үндэсний хороо (одоогоор эрх, үүрэг нь төдийлөн тодорхой бус байгаа)-той уялдаа холбоог нь сайжруулах боломжийг судлах хэрэгтэй гэсэн саналыг өгч байна. ЦАС-гийн ажилтнууд УИХ-ын гишүүдийн дунд сангийн зорилго, чиг үүргийн талаар илүү сайн мэдээлэл өгөх хэрэгтэй гэж үзэж байна.

3.2 Үндэсний хороо

3.2.1 Ерөнхий мэдээлэл


2010 онд Ерөнхийлөгч Улаанбаатар болон бусад томоохон хотуудын агаарын бохирдлыг бууруулах зорилготой Үндэсний хороо байгуулах ажлыг эхлүүлсэн. Тус хороо нь

Ерөнхийлөгчийн тамгын газрын дэргэд ажилладаг. Тус хороо нь Монгол орны агаарын чанарыг сайжруулах бодлого боловсруулж, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг уялдуулан зохион байгуулж, хяналт тавих үүрэгтэй ажилладаг. Тус хороо байгуулагдсан явдал нь “Түлш солих үйл ажиллагааны ерөнхий бүдүүвч” баримт бичигт тусгасантай харьцуулахад ЦАС болон төслийн хувьд чухал өөрчлөлт авчирсан. Хорооны гол зорилго нь **‘агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулах’**-д чиглэнэ.

Тус хорооны эрх зүйн үндэс нь Агаарын тухай хуулийн зөвхөн нэг зүйл ангиар тодорхойлогдож байна. Уг зүйл ангид дараах заалтууд байна: Ерөнхийлөгч Хороог байгуулна. Хороо нь улсын төсвөөс санхүүжнэ. Хорооны ажиллах журмыг Ерөнхийлөгч батлана.

Хорооны чиг үүргээс бусад асуудал дүрэм журмаар зохицуулагдах ч түүний үйл ажиллагааны чиг хүрээ хууль тогтоомжид тодорхой зааж өгөх хэрэгтэй байна.

Зураг: Үндэсний хорооны бүрэлдэхүүн



Нарийн бичгийн дарга
Үндэсний хорооны ажлын албаны дарга

3.2.2 ЦАС-тай албан ёсны уялдаа холбоо

Үндэсний хороо, ЦАС-гийн аль аль нь агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ажиллаж байгаа ч энэ хоёр байгууллагын хоорондын уялдаа холбоог хууль тогтоомжинд тодорхой зааж өгөөгүй байна.

ЦАС-гийн Удирдах зөвлөл: энэ хоёр байгууллагын өнөөгийн бүтцээр тус хоёр байгууллагын Удирдах зөвлөлд орсон байгууллагуудын төлөөлөл нэлээд давхцаж байна. ЦАС-гийн Удирдах зөвлөлд Байгаль орчин, аялал жуулчлал, Эрүүл мэнд, Сангийн сайд нар, УБ хотын Орлогч дарга орсон бол Үндэсний хорооны удирдах зөвлөлд тухайн яамдын Төрийн нарийн бичгийн дарга нар болон УБ хотын захирагч оролцож байна. Харин үндэсний хорооны ажлын алба ЦАС-гийн Удирдах зөвлөлд төлөөлөлгүй байна.

Ерөнхийлөгчийн зарлигаар Үндэсний хороонд агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, холбогдох талуудад үүрэг даалгавар өгөх, хэрэгжилтийг хянах эрх, үүрэг олгогджээ. Бусад зарим байгууллагуудын хувьд энэ эрх, үүрэг давхардан олгогдсон байгааг эргэн авч үзэж, засаж залруулах шаардлагатай.

Захиргааны шатлал: ЦАС нь Үндэсний хорооны зааварчилгааг дагаж биелүүлэх ёстой. Хороо нь асуудлыг авч үзэн шийдвэр гаргадаг. Үүнийг ЦАС-гийн дүрэмд тодорхой зааж өгөх хэрэгтэй. Түүнчлэн ЦАС Үндэсний хороотой харилцаж, шийдвэр гаргуулдаг албан ёсны механизмыг тогтоож өгөх хэрэгтэй.

Тайлагнах үйл явц: Тайлагнах үйл явцын талаар өнөөгийн хууль тогтоомжинд албан ёсоор тусгасан зүйл байхгүй учраас Үндэсний хорооноос шаардахгүй л бол ЦАС тайлагнах шаардлагагүй нөхцөл байдал үйлчилж байна. Иймээс тайлагнах үйл явцын талаар албан ёсны механизм бий болгох хэрэгтэй. Түүнчлэн бусад байгууллагуудын хувьд ч албан ёсоор тогтоосон уялдаа холбоо байхгүй, эхэндээ Үндэсний хороонд ажлаа тайлагнадаг байсан боловч сүүлдээ тайлан ирүүлэхээ больсон байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилт: Үндэсний хороо нь ЦАС-гийн үйл ажиллагааны хүрээнд хууль тогтоомж хэрэгжүүлэх ажилд оролцдоггүй. ЦАС нь энэ тал дээр үндсэндээ УБ хотын захиргаатай хамтран ажилладаг бөгөөд хотын захиргаа нь дүүргүүд, хороо, хэсгийн ахлагчидтай хамтран ажилладаг.

3.3 Агаарын чанарын мэргэжлийн алба

3.3.1 Ерөнхий мэдээлэл

Үндэсний агаарын чанарын мэргэжлийн алба нь Ус цаг уур орчны шинжилгээний газар (УЦУОШГ)-ын дэргэд хоёр ажилтантайгаар 2006 онд байгуулагдсан. Тус алба нь 2008 онд БОАЖЯ-нд шилжсэн ч 2010 онд эргээд УЦУОШГ-д ирсэн. Одоогоор 9 ажилтантай ажиллаж байна. Тус алба нь агаарын чанарын хяналт мониторинг явуулах, агаарын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, холбогдох стандартуудыг боловсруулах чиглэлээр ажиллахаас гадна орон нутгийн алба нэгжүүдэд шаардлагатай техникийн дэмжлэг үзүүлж ажилладаг. Үйл ажиллагаанд нь хяналт мониторингийн тоног төхөөрөмж маш чухал бөгөөд тус албанаас орон нутгийн алба нэгжүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлдэг байна. Хамгийн чухал ажил үүрэг нь агаарын чанарын талаарх мэдээлэл цуглуулж, агаарын чанарын индекс тодорхойлон мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлдэг. Үндэсний

агаарын чанарын мэргэжлийн алба нь Улаанбаатар хотын агаарын чанарын тайланг гарган шаардлагатай үед засгийн газрын холбогдох байгууллагуудад хүргүүлдэг (долоо хоногийн, арван хоног тутмын, сарын, жилийн тайлангууд). Түүнчлэн аж ахуй нэгж, байгууллага, хувь хүмүүсийн хүсэлтээр агаар бохирдуулагч эх үүсвэрийн бохирдуулагч бодисыг хэмжих, тэдгээрийн ялгаруулалтыг бууруулах талаар зөвлөх үйлчилгээг үзүүлдэг. Үндэсний агаарын чанарын алба нь 40 агаарын чанарын хяналтын станцтай бөгөөд тэдгээрийн 15 нь УБ хотод (4 нь УБ хотын агаарын чанарын албанд, 11 нь Агаарын чанарын мэргэжлийн албанд харъяалагддаг) ба 25 нь аймаг, орон нутагт байдаг. Эдгээр 25 станцийн 11 нь лаборатори байсан бөгөөд үлдсэн нь станц байна. Энэ жилээс Азийн хөгжлийн банкны дэмжлэгээр бүх станцийг лаборатори болгохоор ажиллаж байна. УБ дахь станциудын 11 цэг нь хүхэрлэг хий /SO₂/, азотын давхар исэл /NO₂/, 8 цэг нь нүүрстөрөгчийн дутуу исэл /CO/, 7 цэг нь том ширхэгт тоосонцор /PM₁₀/, 2 нь нарийн ширхэгт тоосонцор /PM_{2.5} / -ыг тус тус хэмжиж тогтоодог. Орон нутгийн хяналтын харуулууд зөвхөн хүхэрлэг хий /SO₂/ азотын давхар исэл /NO₂/-ийг хэмждэг байна.

3.3.2 ЦАС-тай албан ёсны уялдаа холбоо

Өнгөрсөн жил ЦАС нь БОАЖЯ-аар дамжуулан Агаарын чанарын мэргэжлийн албанд шаардлагатай тоног төхөөрөмж, лаборатори худалдан авах ажлыг санхүүжүүлсэн. Тендер, зарлан нийлүүлэгчдийг сонгох, гэрээ хийх ажлыг Агаарын чанарын мэргэжлийн алба өөрөө гүйцэтгэсэн. Тоног, төхөөрөмжийн худалдан авалтыг төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийн хүрээнд нээлттэй тендер зарлан явуулсан. Түүнчлэн агаарын чанарт хяналт тавих, тогтолцоог сайжруулах талаар ЦАС-д зөвлөгөө өгч ажилладаг.

3.4 Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

3.4.1 Ерөнхий мэдээлэл

Үндэсний болон орон нутгийн хэмжээнд ажиллаж байгаа бүх улсын байцаагчид нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ)-т харъяалагддаг. Боловсруулсан түлш нэвтрүүлэх туршилтын ажиллагааны хүрээнд үйлдвэрлэгчид ба хэрэглэгчдээр холбогдох дүрэм журмыг сахиулах, дагаж мөрдүүлэхэд улсын байцаагчдын үүрэг, оролцоо чухал юм.

3.4.2 ЦАС-тай албан ёсны уялдаа холбоо

ЦАС-тай албан ёсны ажлын холбоо байхгүй. Хяналт шалгалтыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд явуулдаг. Хууль, тогтоомжийн хэрэгжилтийн механизмуудыг бид тусгайлан авч үзэж, тайланг тусад нь гаргана.

3.5 БОАЖЯ

3.5.1 Ерөнхий мэдээлэл

БОАЖЯ-ны үйл ажиллагааны чиглэлийг Засгийн газрын тухай хууль (1993-5-6), Яамныэрхзүйн байдлын тухай хууль (2004-4-15)-уудад тус тус заасан. Эдгээр хуулинд БОАЖЯ нь *“сайдад эрхлэх асуудлынхаа хүрээнд стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг нь зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөхөд нь мэргэжил, арга зүй, эрх зүй, техник, зохион байгуулалтын үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ”*. Сайд нь дор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалтын болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ. Үүнд:

- байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх болон экологийн бодлого;
- цөлжилттэй тэмцэх болон ойжуулалтын асуудал;

- усны нөөцийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах асуудал;
- ургамал, ан амьтны нөөцийг хамгаалах асуудал, мэдээллийн сан;
- байгаль орчны шинжилгээ, ус, цаг уур болон байгалийн болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, экологийн аюулгүй байдлыг хангах асуудал;
- биоаюулгүй байдлын бодлогын асуудал;
- аялал жуулчлалын бодлого.

3.5.2 ЦАС-тай албан уялдаа холбоо

ЦАС-тай шууд холбоотой нь БОАЖЯ өөрөө бус харин Сангийн Удирдах зөвлөлийн даргаар ажиллаж буй сайд юм. ЦАС-гийн төсвийг тус салбарын төсөвт багтаан сайдын багцад оруулсан байдаг.

ЦАС-гийн үйл ажиллагаа БОАЖЯ-ны үйл ажиллагаатай шууд уялдаж, яамны шууд удирдлаганд ажилладаггүй. Харин Байгаль хамгаалах сан ба Аялал жуулчлалын сан (Сайдын зөвлөх ба Аялал жуулчлалын газрын дарга удирддаг) нь БОАЖЯ-ны сангууд юм. ЦАС нь яамд хоорондын сан учраас холбогдох яамдын сайд нарыг Удирдах зөвлөлдөө оруулсан байдаг.

ЦАС-гаас санхүүжүүлж буй үйл ажиллагаанууд ихэвчлэн Монгол улсын дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаанууд байдаг. БОАЖЯ бол уг хөтөлбөрийг боловсруулсан байгууллагуудын нэг. ЦАС-гийн санхүүжилтээр БОАЖЯ-ны хэрэгжүүлдэг үйл ажиллагааны тухайд яам төслийн саналаа ЦАС-гийн Удирдах зөвлөл /хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэлэлцэн батладаг/-д явуулж хэлэлцүүлдэг. Батлагдсан тохиолдолд яам тухайн төслийн захиалагч нь болдог. Одоогоор ЦАС-гийн ихэнхи үйл ажиллагааг БОАЖЯ хариуцан хэрэгжүүлж байна. Тендэр зарлах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, хяналт мониторинг хийх гээд төсөл хэрэгжихтэй холбоотой бүх асуудлыг БОАЖЯ хариуцан явуулдаг. Зөвхөн төлбөр тооцоог ЦАС хариуцдаг. ЦАС нь гэрээний нэг тал болон гэрээнд гарын үсэг зурдаг ч, гэрээний эхийг БОАЖЯ бэлтгэдэг. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тендерийн хороо байгуулдаг бөгөөд уг хороонд ЦАС-ийн төлөөллийг урьж оролцуулдаг. Ихэвчлэн ЦАС-гийн Гүйцэтгэх захирал эсвэл түүний төлөөлөл тендерийн хороонд оролцдог. Түүнчлэн ЦАС хяналт мониторингийн ажилд оролцдог ч энэ нь тэдний албан ёсны үүрэг биш байна.

БОАЖ-ын сайд нь ЦАС-гийн Удирдах зөвлөлийг удирддаг ч нөгөө талаас ЦАС-гийн захиалагч нь болдог. Энэ давхар үүргээс үүдэх асуудлыг дүрэм журмаар зохицуулах хэрэгтэй гэдэг нь харагдаж байна.

БОАЖЯ-ны зүгээс ЦАС-гийн үйл ажиллагаатай холбоотой бодлого, төлөвлөлт явуулах албан ёсны тогтолцоог бий болгох хэрэгтэй гэж үзэж байна. Одоогоор ЦАС-гийн Удирдах зөвлөл нь албан ёсны удирдамж, чиглэл, урт хугацааны төлөвлөлтгүйгээр санхүүжүүлэх төслүүдийн талаарх шийдвэрээ гаргаж байна. Засгийн газрын урт хугацааны төлөвлөлтийн өнөөгийн баримт бичигт ЦАС-гаас санхүүжүүлэх үйл ажиллагааг тусгайлан заагаагүй байна.

3.6 Сангийн яам

3.6.1 Ерөнхий мэдээлэл

Засгийн газрын тухай хууль (1993), Яамны эрхзүйн байдлын тухай хууль (2004)-д зааснаар тус Яам нь *“сайдад эрхлэх асуудлынхаа хүрээнд стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг нь зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөхөд нь мэргэжил, арга зүй, эрх зүй, техник, зохион байгуулалтын үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ”*. Сайд нь дор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт,

боловсруулалт, удирдлага, зохицуулалтын болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ. Үүнд:

- улсын нэгдсэн төсвийн талаархи судалгаа, төлөвлөлт;
- улсын болон орон нутгийн төсвийн зарцуулалтын хяналт;
- төсвийн хөрөнгө оруулалтын бодлого;
- зээл, тусламжийн нэгдсэн бодлого;
- нягтлан бодох бүртгэлийн бодлого;
- гаалийн бодлого;
- татварын бодлого;
- даатгалын бодлого;
- санхүүгийн зах зээл, төсвийн орлого, зарлага, өрийн удирдлагын асуудал.

3.6.2 ЦАС-тай албан уялдаа холбоо

ЦАС нь орлого, зарцуулалтын асуудлаар Сангийн яамтай холбоотой ажилладаг. Татварын ерөнхий газар нь агаарын бохирдлын төлбөрийг хурааж Төрийн санд төвлөрүүлдэг. Сангийн яамны Орлогын хэлтэс оны эхэнд тухайн жилд агаарын бохирдлын төлбөрөөс орох орлогын тооцоог урьдчилан гаргадаг. Уг тооцоонд үндэслэн ЦАС-гийн Удирдах зөвлөл төсвөө баталдаг. Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын Зарлагын хэлтэс төсвийг хянаж, урьдчилан тооцоолсон орлогоос давсан эсэхийг нягталж үздэг. Сангийн яамнаас өгсөн бусад мэдээлэл:

- Сангийн яам нь ЦАС-гийн төсвийг хянаж баталдаг. ЦАС-гийн данс Төрийн санд байршдаг. ЦАС нь төсвийн төлөвлөлтөө хийж, БОАЖЯ, Сангийн яамдаар хянуулсны дараа УИХ-аар батлуулдаг.
- Одоогоор ЦАС нь улсын төсвөөс бүрэн санхүүжиж байна.
- Төрийн сан ЦАС-гийн жилийн ажлын төлөвлөгөө, төсөв, гүйцэтгэлд үндэслэн ЦАС-гийн санхүүжилтыг олгодог.
- ЦАС нь аливаа бараа, үйлчилгээг худалдаж авах гэрээ байгуулахын өмнө үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхийг зөв үнэлж, сонгон шалгаруулах ёстой. Боловсруулсан түлш үйлдвэрлэгчидтэй 2011 онд байгуулсан гэрээ нь үйлдвэрлэгчдийн хүчин чадал хангалтгүйгээс бүрэн биелэгдээгүй байна.
- Тусгай сангуудын өөрсдийн орлогын эх үүсвэрээс олсон орлогыг дансанд нь үлдэх боломжтой болгохоор Засгийн газрын Тусгай сангийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулахаар Сангийн яам ажиллаж байна.

3.7 Эрдэс баялаг, эрчим хүчний яам

3.7.1 Ерөнхий мэдээлэл

Тус яам нь *“сайдад эрхлэх асуудлынхаа хүрээнд стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг нь зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөхөд нь мэргэжил, арга зүй, эрх зүй, техник, зохион байгуулалтын үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ”*. Сайд нь дор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалтын болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ. Үүнд:

- Геологи, эрдэс баялагийн талаар баримтлах бодлого
- Газрын тосны талаар баримтлах бодлого
- Эрчим хүчний нэгдсэн бодлого
- Түлш, эрчим хүчний үйлдвэрлэл, түгээлт
- Сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл
- Түлш эрчим хүчний бүс нутгийн бодлого
- Эрчим хүчний шинэ нөөц бий болгох ашиглах асуудал
- Хүнд үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлого

3.7.2 ЦАС-тай албан уялдаа холбоо

Тус яам нь ЦАС-тай хэд хэдэн замаар холбогддог. Тухайлбал нүүрсний салбар, нүүрсний үйлдвэрлэл нь ЦАС-гийн орлогын гол хэсгийг бүрдүүлдэг. Түүнчлэн боловсруулсан түлш бий болгох, ашиглахтай холбогдсон бодлогыг энэ яам хариуцдаг. Тус яамны төлөөлөл ЦАС-гийн Удирдах зөвлөлд орсон нь тус яамтай хамтран ажиллах механизмыг бүрдүүлдэг. Агаарын бохирдолтой холбоотой асуудлыг урьд нь энэ яам хариуцдаг байсан бол одоогоор Үндэсний хороо болон яамд хоорондын сан болох ЦАС хариуцан ажиллах болсныг яам дэмжиж байгаа. Яамны агаарын бохирдлын талаарх одоогийн гол үүрэг бол холбогдох үйл ажиллагааны талаар техникийн зөвлөгөө өгөх, ЦАС-гаас санхүүжих төслийн санал гаргах зэрэг болно. Түүнчлэн яамны оролцоотой нэг чухал үйл ажиллагаа бол түлш, зуухны нийлүүлэлтэнд олгож байгаа татаасын асуудал юм. Агаарын бохирдлын төлбөрийн тогтолцоо, ЦАС-г байгуулах ажлыг ЭБЭХЯ-наас санаачлан эхлүүлсэн ч хожим яам хоорондын шинэ бүтцийн нэг хэсэг болсон билээ. Агаарын бохирдлыг бууруулах одоогийн бүтэц нь Үндэсний хороогоор удирдуулсан яамд хоорондын бүтэц учраас холбогдох талуудын өмнө хүчгүйдэх, тушаал шийдвэрийг нь дагахгүй байх асуудал харьцангуй бага юм. Урьд нь ЭБЭХЯ-наас холбогдох талуудын хооронд зохицуулалт хийхэд нэлээд төвөгтэй байсан байна.

Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн үндэсний бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг тэр бүр хангахгүй, утааг бууруулахад үр нөлөө багатай зарим үйл ажиллагааг санхүүжүүлэх явдал гарч байна. Жишээлбэл, сангийнхны мэдээлснээр 2012 оны төсвийн тодотголоор ЦАС-нд 105 тэрбум төгрөг батлагдсаны 80 тэрбум төгрөг нь Улаанбаатарын агаар бохирдлыг дөнгөж 6%-ийг бүрдүүдэг Дулааны цахилгаан станциудыг сайжруулахад зарцуулагдахаар байна. Иймд санхүүжүүлэх үйл ажиллагааг сонгон шалгаруулах маш сайн шалгууртай болох нь тэргүүлэх ач холбогдолтой үйл ажиллагааг олж тогтооход тус дөхөм болох юм. Иймд ЦАС нь санжүүжүүлэх үйл ажиллагааны талаар холбогдох яамд, байгууллагуудаас мэргэжлийн зөвлөгөө авдаг байх хэрэгтэй байна.

3.8 Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам

3.8.1 Ерөнхий мэдээлэл

Тус яам нь *“сайдад эрхлэх асуудлынхаа хүрээнд стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг нь зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлгээ өгөхөд нь мэргэжил, арга зүй, эрх зүй, техник, зохион байгуулалтын үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ”*. Сайд нь дор дурдсан хүрээний бодлогын төлөвлөлт, боловсруулалт, удирдлага, зохицуулалтын болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрхэлнэ. Үүнд:

- Зам, тээврийн салбар, түүний зохицуулалтыг сайжруулах талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх,
- Төмөр замын тээвэр
- Иргэний агаарын нислэг
- Авто замын тээвэр
- Авто зам
- Далай, усан замын тээврийг хөгжүүлэх
- Барилга ба барилгын материалын үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлого
- Хот байгуулалт ба архитектур
- Орон сууцны бодлого
- Нийтийн ахуй үйлчилгээ
- Газар ашиглалтын төлөвлөлтийн бодлого, геодези, зураг зүй.

3.8.2 ЦАС-тай албан уялдаа холбоо

Тус яам ЦАС-гаас санхүүждэг үйл ажиллагаануудаараа дамжуулан ЦАС-тай холбогддог. Өнгөрсөн жил ЦАС нь автобусны түлшийг шингэрүүлсэн хийн түлшээр солих ажлыг

санхүүжүүлсэн (нийт 800-гаас 43-г шилжүүлээд байгаа). Түүнчлэн ЦАС-гийн дэмжлэгтэйгээр авто машинд шүүлтүүр байрлуулах, 4 хийн түлшний станц байгуулах ажлууд хийгдсэн ч эдгээр ажлуудыг УБ хотын захиргаа хариуцсан.

Яамны төлөөлөл ЦАС болон Үндэсний хорооны Удирдах зөвлөлд байдаг ба хэрэгжүүлэх үйл ажиллагааны саналаа ЦАС-гийн удирдах зөвлөлд байдаг төлөөллөөрөө дамжуулан танилцуулдаг. Саналууд нь дунд хугацааны үндэсний хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдсан байх ёстой.

3.9 УБ хотын захиргаа

3.9.1 Ерөнхий мэдээлэл

УБ хотын захиргаа нь хотын агаарын бохирдолтой холбоотой хууль, бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд хяналт тавих үүрэгтэй ажилладаг. Түүнчлэн УБ хотын агаарын чанарын албаар дамжуулан хотын агаарын чанарт хяналт тавих үүрэгтэй. УБ хотын агаарын чанарын алба нь 7 хүний бүрэлдэхүүнтэй 2006 онд УБ хотын Захирагчийн албаны нэг нэгж болон байгуулагдсан. Дараа нь 2009 онд 16 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр хэрэгжүүлэгч агентлаг болж өргөжсөн. УБ хотын агаарын чанарын албаны гол үүрэг нь УБ хотын агаарын бохирдлын гол параметруудад хяналт тавьж холбогдох талууд болон олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. УБ хотын агаарын чанарыг 13 хяналтын цэгт хянаж байгаа бөгөөд эдгээрийн 4 цэг нь хотын захиргаанд 9 нь БОАЖЯ-ны харъяанд ажиллаж байна. Агаарын чанарын алба нь Засгийн газар болон хотын захиргаанаас гаргасан дүрэм журмыг хэрэгжүүлж, стандартыг боловсруулах үүрэгтэй ажилладаг. УБ хотын Захирагчийн алба нь уг нэгжийг санхүүжүүлдэг. Уг нэгж нь ЖАЙКА олон улсын байгууллагатай ойр хамтран ажилладаг. Улаанбаатарын агаар чанарын алба нь бодлого боловсруулж, донорын зохицуулалтын асуудлыг хариуцдаг газар биш юм.

Байгууллагын бүтцийн төлөвлөлт:

1. Захирал
2. Орлогч захирал
3. Цахилгаан хангамжийн инженер, ахлах ажилтан
4. Хүний нөөцийн ба хуулийн ажилтан
5. Мэдээлэл технологийн ажилтан
6. Нам даралтат зуухны асуудал хариуцсан ажилтан
7. Хяналтын цэг хариуцсан ажилтан
8. Хот төлөвлөлт, дэд бүтцийн ажилтан
9. Хяналт шалгалтын сүлжээ, хэмжил зүйн ажилтан
10. Гэр хорооллын агаарын бохирдлын асуудал хариуцсан ажилтан
11. Тээврийн хэрэгслийн бохирдол хариуцсан ажилтан
12. Нүүрсний технологийн асуудал хариуцсан ажилтан
13. Хий, шингэн түлшний асуудал хариуцсан ажилтан
14. Администратор
15. Физик, химийн сөрөг нөлөөллийн асуудал хариуцсан ажилтан
16. Агуулах, хадгалалт хариуцсан гэрээт ажилтан

3.9.2 ЦАС ба УБ хотын агаарын чанарын албаны хоорондын албан уялдаа холбоо

УБ хотын захиргаа нь ЦАС-гийн гол хамтрагч байгууллагуудын нэг. Түүний төлөөлөл нь Сангийн Удирдах зөвлөлд байдаг нь үйл ажиллагааг төлөвлөн хамтран ажиллах боломж олгодог. Түүнчлэн хотын захиргаа нь боловсруулсан түлш нэвтрүүлэх туршилтын ажлыг

хэрэгжүүлэх, сайжруулсан зуух, нам даралт зуухны татаас олгох ажилд гол хамтрагч байгууллага болж оролцдог. Хамтран ажиллах гэрээг БОАЖЯ, ЦАС, Хотын захиргаа болон гэрээт үйлдвэрлэгч компаниудын хооронд байгуулсан. Хотын захиргаа бусад талуудтай хамтран голлох үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж оролцдог. УБ хотын захиргаа нь хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны тайлангаа гаргадаг ч ЦАС-д тэр бүр тогтмол явуулдаггүй. Үүнийг саяхан хийгдсэн аудитын дүгнэлтэд зөрчил болгон дурьдсан байсан.

ЦАС нь хамтрагч байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгох хэрэгтэй гэж үзэж байна. Тухайлбал УБ хотын захиргаа нь ЦАС-гийн Удирдах зөвлөлийн гишүүн үү, эсвэл үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэгч тал (захиалагч) уу гэдгийг тодорхой болгоогүйгээс үүсч болох асуудлаас сэргийлэхийн тулд энэ асуудлыг хуулиар тодорхой болгох ёстой. Санхүүжүүлэх болон ажлаа тайлагнахад хамтрагч талуудаа хариуцлагатай ханддаг болгох үүрэг, хариуцлагын механизм одоогоор ЦАС-д байхгүй байна. ЦАС-гаас санхүүжиж буй төслүүдийн хэрэгжилтийн тайлангууд зарим нь дутуу, зарим нь бүр байхгүй байгааг ЦАС өөрөө 100% хариуцах ёстой гэж Үндэсний аудит дүгнэж байна.

Гэрээний тухайд тогтсон темплэт/загвар байхгүй, ЦАС болон захиалагчид хэлэлцэн тохиролцож гэрээний эхийг боловсруулж байна. 2011 онд гүйцэтгэгч тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас гэрээний хэрэгжилтэнд ноцтой асуудал үүсч, гүйцэтгэгч багагүй хэмжээний торгууль төлөхөд хүрч байсан. Торгуулийг ямар хэмжээгээр төлөх нь ч тодорхой бус байсан байна. Хууль, тогтоомжийн хэрэгжилтийн асуудлаар УБ хотын захиргаа БОАЖЯ-тай хамтран ажилладаг ч энэ талд ЦАС-тай хамтардаггүй. ЦАС-гийн ажилтнууд хяналт мониторингийн ажилд оролцдог ч энэ нь сайн дурын үндсэн дээр хийгддэг. Хяналт мониторингийн ажлын зардлыг оролцогч талууд өөрсдөө хариуцдаг.

Хотын захиргаанд нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах арга жэмжээнд зориулсан төсөв хуваарилагддаг. Төсвийн зарцуулалт зарим талаар ЦАС-гийн үйл ажиллагаатай яг давхцсан тохиолдол ч байна. Жишээлбэл: Хоёр байгууллагын 2012 оны төсөвт аль алинд нь шалны цахилгаан халаагуурт зориулсан төсөв тусгагдсан байна. Энэ чиглэлийн төсөв ЦАС-д төвлөрөх нь зүйтэй гэж үзэж байна.

3.9.3 ЦАС ба УБ хотын Байгаль хамгаалах газар хоорондын албан ёсны ажлын уялдаа холбоо

УБ хотын Байгаль хамгаалах газар нь БОАЖЯ ба Хотын захиргаагаар дамжуулан цөөн тооны жижиг хэмжээний төслийн санал ЦАС-д ирүүлж байснаас өөрөөр ЦАС-тай хамтарч ажиллаж байгаагүй. Гэр хорооллын бие засах газруудыг ариутгах халдваргүй болгох; Сэлбэ, Туул голын дагуух газрыг цэвэрлэх ажлуудыг ЦАС-гийн санхүүжилтээр гүйцэтгэсэн. Гэхдээ ЦАС-нд томоохон хэмжээний төслийн санал ирүүлж байгаагүй. УБ хотын Байгаль хамгаалах газрын гол үүрэг, үйл ажиллагаа бол хотын ногоон бүсийг хамгаалах, гол ус, хөрсний бохирдлоос сэргийлэхэд чиглэдэг. Тэдний үзэж байгаагаар хотын агаарын бохирдлыг бууруулахад ойн сан маш чухал үүрэгтэй тул ЦАС-гаас хотын ойн бүсийг хамгаалахад дорвитой санхүүжилт олгох хэрэгтэй. Цаашид УБ хотын Байгаль хамгаалах газар нь энэ талаар санал боловсруулж ирүүлэхээр төлөвлөж байгаа. УБ хотын агаарын чанарын алба нь анх уг газрын дор байгуулагдаж байсан. Одоо энэ хоёр байгууллага нь өөр өөр чиг үүрэгтэй тусдаа байгууллага болсон.

4 Дүгнэлт, зөвлөмж

4.1 Дүгнэлт

ЦАС-гийн өнөөгийн бүтэц зохион байгуулалт нь тус Сангаас санхүүжиж буй үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулдаггүй. Ерөнхийдөө ЦАС-гийн хамтрагч олон байгууллагуудын чиг үүрэг давхцдаггүй, тус Сан нь яамд ба салбар хоорондын санхүүгийн байгууллага болохын хувьд үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж болохоор байна.

Энэ тогтолцоонд байгаа нэг гол асуудал бол агаарын бохирдлыг бууруулахад ЦАС-гийн чиг үйл ажиллагааг илүү тодорхой болгосон урт хугацааны төлөвлөлтийн механизм байхгүй байгаа явдал юм. Урт хугацааны төлөвлөлттэй байх нь талуудад хамтын ажиллагаагаа төлөвлөхөд нь чиглэл болно гэж үзэж байна. Түүнчлэн сайтар боловсруулж тогтоосон сонгон шалгаруулах журам бий болгох хэрэгтэй. Энэ нь нарийн ширхэгт тоосонцор, хүхэрлэг хий, азотын ислүүд зэрэг агаар бохирдуулагч гол элементүүдийн ялгаруулалтыг бууруулахад нөлөө багатай үйл ажиллагаанд ЦАС-гийн санхүүжилтийг зарцуулахаас сэргийлэхэд дөхөм болох учиртай.

ЦАС-гийн үйл ажиллагаанд тулгарч байгаа нэг хүндрэл бол түүний гол хамтрагч байгууллагууд нь Удирдах зөвлөлийн гишүүн болон үйл ажиллагааг хэрэгжүүлэгч/ захиалагч талын аль алины үүргийг гүйцэтгэж байгаа явдал юм. Энэ нь ЦАС-гийн зүгээс төсөл хэрэгжүүлэгч байгууллагуудтайгаа хариуцлага тооцоход хүндрэл учруулж болох талтай. Гэтэл Сангийн яам, Үндэсний аудитын газрын өмнө сангийн хөрөнгийн зарцуулалтын асуудалд ЦАС өөрөө 100%-ийн хариуцлага хүлээж байна. Иймд ЦАС-гийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагуудад хариуцлагын илүү хүчтэй механизмыг бий болгох хэрэгтэй байна.

“Түлш солих үйл ажиллагааны ерөнхий бүдүүвч” баримт бичигт тусгаж төлөвлөсөн зүйлээс хийгдэж биелэгдээгүй байгаа нэг зүйл бол ЦАС-гийн үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо хангалтгүй байгаа явдал юм. Сангийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй биш байгаагаас гадна ТББ-ууд өөрсдийн саналаа ЦАС-д ирүүлж, гэрээгээр үйл ажиллагаа гүйцэтгэгч байх боломж байхгүй байна.

ЦАС болон бусад байгууллага хоорондын зарим уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна. Одоогоор Үндэсний хорооны ажлын албаны төлөөлөл ЦАС-гийн Удирдах зөвлөлд байхгүй байна. Гэвч Үндэсний хорооны чиг үүргийг харахад энэ байдлыг өөрчлөх шаардлагатай нь харагдаж байна. Түүнчлэн ЦАС-гийн төлөвлөлтийг сайжруулахын тулд ЦАС бодлого боловсруулагчид болон мэргэжилтнүүдтэй холбоотой ажиллаж тэдний туслалцааг авдаг болох механизмыг бүрдүүлэх шаардлагатай байна.

4.2 Зөвлөмж

Дээрх дүн шинжилгээнд үндэслэн ЦАС ба бусад байгууллагуудын хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дараах арга хэмжээг авах хэрэгтэй гэж үзэж байна. Тухайлбал:

Ерөнхий тогтолцоо:

- Агаар бохирдуулагч бодисуудыг бууруулахад үзүүлэх нөлөөлөлд нь үндэслэн ЦАС-гийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг оновчтой сонгох тодорхой шалгуурыг бий болгох.
- ЦАС-гаас санхүүжих үйл ажиллагааны хяналт мониторинг, үнэлгээний тогтолцоог бий болгох. Энд үйл ажиллагааны нөлөөллийн үнэлгээг оруулах шаардлагатай. Сангийн дотоод хяналтын механизмыг боловсруулах хэрэгтэй.
- Талуудын оролцоог хангасан олон жилийн төлөвлөлтийн механизмтай болох. Тухайлбал ЦАС-гаас санхүүжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 3 жилээр гаргах. Төлөвлөлтийн үйл явцад ЦАС-ын ажлын албаны оролцоог хангах.
- Хариуцлагын тогтолцоог тодорхой тусгасан тайлагнах механизмыг дүрэм, журманд нь оруулах. Түүнчлэн харилцагч байгууллага бүртэй харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурах, гүйцэтгэгч талуудтай хийх гэрээний загварыг боловсронгуй болгох шаардлагатай. Санамж бичиг болон гэрээний загварыг боловсронгуй болгоход манай төсөл дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.
- ЦАС-гийн санхүүжилт, үйл ажиллагаа нь бусад төрийн байгууллагууд болон олон нийтэд нээлттэй байх. Энэ нь ТББ-уудад ч хамаатай.
- ТББ-ууд төслийн санал ирүүлж, гэрээт гүйцэтгэгч байх боломж нээх. Харин ирүүлэх санал нь тодорхой шаардлага хангасан, Байгаль орчны иргэний зөвлөл болон БОАЖЯ дээр саяхан байгуулагдсан “Байгаль орчинд ээлтэй, экологит хоргүй бүтээгдэхүүнийг дэмжих салбар зөвлөл” гэх мэт холбогдох албанаас дэмжлэг авсан төсөл байх шаардлагатай.
- Жил бүр ЦАС-гийн хүрээнд төлөвлөсөн үйл ажиллагааг хянаж үзэх мэргэжилтнүүдээс бүрдсэн техникийн ажлын хэсгийг байгуулж ажиллуулах. Ийм замаар яамд болон холбогдох мэргэжлийн агентлагуудын мэргэжилтнүүдийн хүчийг ашиглан ЦАС-гийн санхүүжилтийг өнөөгийн төр засгийн бодлоготой уялдуулж, хэрэгжилтийг нь хангахад чиглүүлэхээс гадна гол бохирдуулагчдыг бууруулахад хамгийн нөлөөлөл ихтэй үйл ажиллагаануудыг сонгоход дөхөм болно.
- ЦАС-гаас санхүүжилт хүссэн үйл ажиллагаануудад байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл (Байгаль орчны стратегийн үнэлгээ байж болох юм)-ийг нь БОАЖЯ авч үздэг байх хэрэгтэй.

ЦАС-гийн Удирдах зөвлөл:

- ЦАС-гийн Удирдах зөвлөлийн бүтцийг хянан үзэж, Удирдах зөвлөлийн журамд чиг үүргийн зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар тодорхой зааж өгөх.

Санхүүжилт ба гэрээний асуудлууд:

- Агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний төсвийн хуваарилалтын давхцлыг арилгах, энэ чиглэлийн төсвийг ЦАС-нд төвлөрүүлэх.
- Агаарын бохирдлын хураамж төлбөрөөс орсон орлогыг санд хадгалж үлдээх талаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах (уг саналыг Сангийн яам эхлүүлчихсэн байгаа).
- ЦАС-гийн төсвийн төлөвлөлтийн асуудлаар ажилтнуудад сургалт явуулах.

Doc title

- ЦАС гэрээгээр ажил гүйцэтгэгчдийн гүйцэтгэл, үнэлгээний стандартуудыг тогтоох.
- Гэрээний хэлэлцээр хийх, гэрээний санхүүжилт болон гэрээний эх бэлдэх асуудлуудаар ЦАС-гийн ажилтнуудын чадавхи бий болгох, бэхжүүлэх шаардлагатай.
- Гэрээний явцад гарч болох хүндрэлээс сэргийлж түлш үйлдвэрлэгчид зэрэг гол хамтрагч талуудын чадавхийг үнэлэхэд нь ЦАС, УБ хотын захиргаанд дэмжлэг үзүүлэх.

Хавсралтууд

Хавсралт А – Судалж танилцсан баримт бичгийн жагсаалт

Хууль тогтоомж ба бодлогын баримт бичгүүд:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Байгаль орчныг хамгаалах тухай хууль
3. Агаарын тухай хууль
4. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль
5. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль
6. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
7. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
8. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
9. Яамны эрхзүйн байдлын тухай хууль
10. Үндэсний хөгжлийн стратеги

Цэвэр агаарын сан

11. Засгийн газрын 2010 оны 273 дугаар тогтоол
12. Цэвэр агаарын сангийн дүрэм
13. ЦАС-гийн Удирдах зөвлөлийн журам
14. ЦАС-гийн Удирдах зөвлөлийн 3 дахь хурлын тэмдэглэл

Ашигласан материал:

15. УБ хотын агаарын бохирдол – Нөхцөл байдал, бохирдлыг бууруулах арга хэмжээний үр ашгийг үнэлэх судалгааны ажил (2009) Дэлхийн банк